

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Будын Дашдорж	Дугаар	L255
Оршин суугаа аймаг	Өмнөговь	Оршин суугаа сум	Ханхонгор сум
Төрсөн газар	Ханхонгор сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан, Улсын сайн малчин, улсын алдарт уяач		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Таван Овоотын хийд	Сүм хийдийн дугаар	ӨГХХ 019
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 7	Ярилцлага авсан хүн	Ц.Гантулга



Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Таван Овоотын хийд

Гантулга: За та тэр Үст Тангадын тухай домог яриагаа ярьж өгөөч?

Дашдорж :Үгүй ээ, үст Тангад гэж нэг их үстэй хүн байсан даа.Тэр чинь ямар ч учиртай хүн байсан юм, хөдөөгүүр яваад л байдаг байсан юм.Тэгээд л тэр Тожгон Тойны бүгийг л дарсан юм гэнэ лээ.Тожгон тойны бүгийг одоо энэ манай хүүхдүүдийн эцэг л жоохон багачуул хошуу хийдийн суварган дээр суудаг байж. Суваргын хийд гэж байсан, тэр хойно.Тэгээд л ...

Гантулга: Цагаан суварга уу?

Дашдорж: Тийм, Цагаан суварга.Тэгээд л ...

Гантулга: Мандал Овоогийн тэр...?

Дашдорж: Тийм, Мандал-Овоогийн.Тэгээд л хэдэн банди нар авчирдаг юм байх л даа.Ямаан тулманд чихчихээд л, заримыг нь чирээд л явдаг.Зарим нь жаал жаал шилбүүр үүрүүлчихсэн ямаан тулам шавхуурдаад л яваад байдаг байсан юм гэнэ лээ. Тэгээд л авчраад л үзүүлдэг, болоогүй ээ явж бай л гэдэг.Авчраад л л явдаг,

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

болоогүй ээ хэд ч хоног явсан юм бэ дээ.Тэгээд л нэг яваад ирсэн чинь харин за даа амыг нь сайн бооно шүү гээд бодвол тэгээд боогоо л биз дээ.Тэгээд газраа бүр заг овоолоод , амархан шатах юм бэлдчихсэн, хотон дотор.Тэгээд л тэрүүнд аваачаад л хийдэг.Тэгээд л галаа ноцоодог.Тэгээд л дарсан юм гэнэ лээ.

Гантулга:Тэр бас нөгөө хялар хатан гэлүү, тэрний домог?

Дашдорж: Хялар хатан ч яахав дээ, нэг тийм жороо мориор л давхиж байдаг, тийм хялдар хатан гээд л явж байдаг.Тэгээд л дандаа жороо мориор гулгуулчихдаг байж. Тэгээд л нэг явж байхад нь ээ зуур нэг хүн үзсэн юм байх даа. Тэгээд л ярих гэсэн чинь харин хөөе би яаруу явна, буцахдаа ярья гэхихээд яараад байна гэхихээд сондуулын шар дуудуулаад том болохгүй байна гэхихээд л давхисан юм гэнэ лээ. Сондуулын шар ч яахав дээ, нэг халуун тогоонд ус хутгачихаад, ширмэн тогоонд, нэг халуун тогоо халуулаад дэргэд нь тавьчихаад номоо уншаад л сууж байдаг юм байх аа.Хялар хатан ч хүрээд ирдэг юм байх аа. Өө хоёр тогоо хавсраад л дардаг, нэг халуун тогоогоор бүрхээд тэгээд л дарсан юм гэнэ лээ.

Гантулга: За баярлалаа.

Дашдорж:Чимэдпүүжээ гэж уг нь Мандал-Овоогийн л айл, хаанахын ч хүн байсан юм.Сондуулын шар лам нэртэй л домог юм гэнэ лээ. Байшинтын хийд гэж сайхан хийд байсан юм.Тэнд л хүүхэд байхад намайг оч л гээд, нүүж явсан юм.Манайх тэнд нүүж явсан юм.Би нэг арван зургаа, долоотой хүүхэд л давхиж явсан.Тэгээд тэнд очсон.Цам л гарч байгаа гээд сүйд л болж байсан.Тийм ч юм болох гээд, ийм ч юм гарах гэж байна гээд , цам л одоо биеийн тамирын л юм билээ дээ, тэр чинь одоо.Жигтэйхэн л чухам , сүйд л болж байсан.

Гантулга: Цамын бүжиг тийм ээ?

Дашдорж: Тийм, одоо бүжиглэж л байгаа юм байлгүй, юм мэдэхгүй.

Гантулга: За баярлалаа, ярилцлага өгсөнд тань.